

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ШИЙДВЭРИЙН 2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА

/Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд/

2018.02.09

Улаанбаатар хот

## НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт “Засгийн газрын гишүүд хагас жил тутам хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичгийн болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаархи тайланг холбогдох Байнгын хороонд ирүүлнэ” гэж заасан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн тайланд шинжилгээ хийж, ирүүлсэн санал дээр үндэслэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд гаргасан хууль тогтоомжийг хяналтаас хасах саналыг хавсарган хүргүүлж байна.

“Монгол Улсын Засгийн газарт хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн 2017 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн танилцуулга”-ыг Улсын Их Хурлын [www.parliament.mn](http://www.parliament.mn) цахим сүлжээнд байршуулсан болно.

## ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД ТУСГАЙЛАН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

### 2.1. Монгол Улсын хуулийн хэрэгжилт

Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс 2017 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд хууль хэрэгжүүлэхтэй нийцүүлэн холбогдох дүрэм, журам, жагсаалтыг батлан гаргах үүрэг өгсөн Монгол Улсын 110 хуулийн 544 хэсэг, заалтыг мэдээллийн санд бүртгэж, хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын 77 хуулийн 196 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн нь хяналтанд авсан нийт хуулийн 44 хууль буюу 40.0 хувь, 127 хэсэг, заалт буюу 23.3 хувийнх нь хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна. Үлдсэн 33 хуулийн 69 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээний хувьд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас өмнөх онуудад бүрэн хэрэгжиж, хяналтаас хассан хуулиуд байсан бөгөөд хяналтанд авсан 33 хуулийн 348 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй болно.

		Хууль	Хэсэг, заалт
1	2017 оны эхний хагас жилийн байдлаар хяналтанд авсан	110	544
2	Засгийн газраас ирүүлсэн Үүнээс:	77	196
-	Хяналтанд байгаа	44	127
-	Өмнөх онуудад бүрэн хэрэгжиж хяналтаас хассан	33	69
3	Засгийн газраас 2017 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	33	348

Хяналтанд байгаа хуулийн хэрэгжилтийг авч үзвэл, давхардсан тоогоор 14 хуулийн 21 хэсэг, заалт буюу 16.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 17 хуулийн 30 хэсэг, заалт буюу 23.6 хувь нь хэрэгжих шатанд байгаа, 16 хуулийн 51 хэсэг, заалт буюу 40.2 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 10 хуулийн 14 хэсэг, заалт буюу 11 хувь нь хэрэгжээгүй, 4 хуулийн 11 хэсэг, заалт буюу 8.7 хувь нь хугацаа болоогүй байна<sup>1</sup>.

## **2.2. Монгол Улсын хуулиар Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд тусгайлан үүрэг өгсөн заалтын хэрэгжилт**

Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Монгол Улсын 13 хуулийн 26 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны эхний хагас жилийн байдлаар нийт 13 хуулийн 24 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна. Үүнээс мэдээллийн санд хяналтад авсан 9 хуулийн 18 заалт хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн ба хяналтанд байхгүй 6 хуулийн 6 заалт байх ба 5 хуулийн 8 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн мэдээнд үндэслэн хуулийн хэрэгжилтийг авч үзвэл давхардсан тоогоор 3 хуулийн 6 хэсэг, заалт буюу 33.3 хувь нь бүрэн хэрэгжсэн, 2 хуулийн 2 хэсэг, заалт буюу 11.1 хувь нь хэрэгжих шатанд, 1 хуулийн 1 заалт буюу 5.6 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 4 хуулийн 4 хэсэг, заалт буюу 22.2 хувь нь хэрэгжээгүй, 1 хуулийн 5 хэсэг, заалт буюу 27.8 хувь нь хэрэгжих хугацаа болоогүй байна.

	Хууль /давхардсан тоогоор/		Хэсэг, заалт	
	Тоо	Тоо	Хувь	
<b>Хяналтанд авсан</b>	13	26	100.0	
<b>Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй</b>	5	8	30.8	
<b>Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн</b>	9	18	69.2	
<b>Үүнээс:</b>				
- бүрэн хэрэгжсэн	3	6	33.3	
- хэрэгжих шатандаа	2	2	11.1	
- хэрэгжилт хангалтгүй	1	1	5.6	
- хэрэгжээгүй	4	4	22.2	
- хугацаа болоогүй	1	5	27.8	

## **ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР**

### **3.1. Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт**

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс 2017 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн Улсын Их Хурлын нийт 63 тогтоолын 179 заалтыг мэдээллийн сандаа бүртгэж, хяналтанд авсан.

<sup>1</sup> Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд энэхүү журмын 6.3-т заасны дагуу хэрэгжилтийг тооцсон болно.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны эхний хагас жилийн байдлаар Улсын Их Хурлын нийт 44 тогтоолын 105 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна.

Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг авч үзвэл давхардсан тоогоор 23 тогтоолын 37 заалт буюу 35.2 хувь нь бүрэн хэрэгжсэн, 27 тогтоолын 52 заалт буюу 49.6 хувь нь хэрэгжих шатанд, 6 тогтоолын 12 заалт буюу 11.4 хувь нь хэрэгжээгүй, 4 тогтоолын 4 заалт буюу 3.8 хувь нь хэрэгжих хугацаа болоогүй байна.

### **3.2. Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт**

Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн Улсын Их Хурлын 12 тогтоолын 63 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны эхний хагас жилийн байдлаар 6 тогтоолын 25 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна. Үүнээс мэдээллийн санд хяналтад авсан 4 тогтоолын 21 заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн ба мэдээллийн санд байхгүй 3 тогтоолын 4 заалтын мэдээ ирүүлж, 11 тогтоолын 41 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээг авч үзвэл давхардсан тоогоор 4 тогтоолын 9 заалт буюу 42.9 хувь нь хэрэгжсэн, 1 тогтоолын 8 заалт буюу 38.1 хувь нь хэрэгжих шатанд, 1 тогтоолын 1 заалт буюу 4.8 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 тогтоолын 3 заалт буюу 14.2 хувь нь хэрэгжээгүй байна. Мөн 2 тогтоолын 5 заалтын үнэлгээг бууруулан ирүүлсэн байна.

	УИХ-ын тогтоол /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
<b>Хяналтанд авсан</b>	12	63	100.0
<b>Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй</b>	11	41	65.0
<b>Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн</b>	4	21	33.3
<b>Үүнээс:</b>			
- Хэрэгжсэн	4	9	42.9
- Хэрэгжих шатанд	1	8	38.1
- Хэрэгжилт хангалтгүй	1	1	4.8
- Хэрэгжээгүй	1	3	14.2

## **ДӨРӨВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛЫН ТАЛААР**

### **4.1. Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт**

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2017 оны хагас жилийн байдлаар Улсын Их Хурлын Байнгын хорооноос Засгийн газарт үүрэг өгсөн нийт 94 тогтоолын 719 заалтыг хяналтанд авснаас хэрэгжсэн 185 заалт хяналтаас хасагдаж 534 заалт үлдсэн.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны хагас жилийн байдлаар 37 тогтоолын 159 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна. Эдгээр 37 тогтоолын 159 заалтаас 22 тогтоолын 41 заалт буюу 25.8 хувь нь хэрэгжсэн, 27 тогтоолын 99 заалт буюу 62.3 хувь нь хэрэгжих шатанд, 11 тогтоолын 18 заалт буюу 11.3 хувь нь хэрэгжээгүй, 1 тогтоолын 1 заалт буюу 0.6 хувь нь үнэлээгүй ирүүлсэн байна.

#### 4.2. Төсвийн байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Засгийн газарт үүрэг өгсөн Төсвийн байнгын хорооны 9 тогтоолын 34 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналтад авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны эхний хагас жилийн байдлаар 3 тогтоолын 13 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна. Үүнээс мэдээллийн санд хяналтад авсан 2 тогтоолын 10 заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн ба мэдээллийн санд байхгүй 2 тогтоолын 3 заалтын мэдээ ирүүлж, 8 тогтоолын 21 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 2 тогтоолын 10 заалтаас давхардсан тоогоор 2 тогтоолын 2 заалт буюу 20.0 хувь нь бүрэн хэрэгжсэн, 1 тогтоолын 1 заалт буюу 10.0 хувь нь хэрэгжих шатанд, 1 тогтоолын 3 заалт буюу 30.0 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 тогтоолын 4 заалт буюу 40.0 хувь нь хэрэгжээгүй байна.

Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	ТБХ-ны тогтоол /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтанд авсан	9	34	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	8	21	61.8
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	2	10	29.4
Үүнээс:			
- Хэрэгжсэн	2	2	20
- Хэрэгжих шатанд	1	1	10
- Хэрэгжилт хангалтгүй	1	3	30
- Хэрэгжээгүй	1	4	40

#### ТАВ. БҮРЭН БИЕЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗҮЙЛ ЗААЛТЫГ ХЯНАЛТААС ХАСАХ ТУХАЙ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээн дэх хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжсэн дараах хууль тогтоомжийг хяналтаас хасах саналыг ирүүлсэн байна. Үүнд:

Монгол Улсын 3 хуулийн 6 заалт, Улсын Их Хурлын 4 тогтоолын 9 заалт, Төсвийн байнгын хорооны 2 тогтоолын 2 заалт тус тус байна.

Хууль тогтоомж	Хууль тогтоомжийн тоо	Заалтын тоо
Монгол Улсын хууль	3	6
Улсын Их Хурлын тогтоол	4	9
Байнгын хорооны тогтоол	2	2

### **ЗУРГАА. САНАЛ**

1/ Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хууль тогтоомжийн хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээнүүдийн шалтгаан нөхцөлийг тодруулан тайлбарлаагүй, хэрэгжилтийн явцыг тоочих байдлаар нэгтгэн ирүүлсэн байна.

2/ Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ирүүлэхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын дагуу хяналт, шинжилгээ, үнэлгээг хийгээгүй, хэрэгжилт удаашралтай байгаа заалтуудын биелэлтийг сайжруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч, хариуцсан яамд, агентлагуудад хариуцлага тооцдоггүй байдал нь хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлж байна.

3/ Хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд 2012-2016 онд бүрэн хэрэгжиж, хяналтаас хасах санал ирүүлж, холбогдох Байнгын хороонд танилцуулсан хууль тогтоомжийн заалтыг дахин ирүүлэх, эсхүл хэрэгжилтийн хувь хэмжээг бууруулах зэрэг асуудлыг хойшид анхаарах шаардлагатай.

### **МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД  
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ХУУЛИЙН ЖАГСААЛТ**  
/2017 оны эхний хагас жилийн байдлаар/

№	Хуулийн нэр, огноо	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	<b>ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН ТУХАЙ</b> 2016.02.05	7.3. Энэ хуулийн 7.1-д заасан эх үүсвэрийг тооцож Санд төвлөрүүлэх аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1-т заасны дагуу “Ирээдүйн өв сангийн орлогын эх үүсвэрийг тооцож, санд төвлөрүүлэх аргачлал”-ыг Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 10 дугаар тушаалаар батлуулсан.
2	<b>НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ</b> /Шинэчилсэн найруулга/ 2015.06.19	17.1.3. аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн үндэсний болон холбогдох стандарт, журам баталж, мөрдүүлэх;	Сангийн сайдын 2016.11.15-ны өдрийн 378 тоот тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны анхдугаар хурал 2016.12.06-ны өдөр хуралдаж, “Хайгуул болон олборлох салбарын нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ын төсөл, “Барилгын гэрээний орлого ба зардлын нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ын төсөл, “Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ын төслийг тус тус хэлэлцээд, хорооны гишүүдээс гаргасан саналыг тусгасны үндсэн дээр Сангийн сайдын тушаалаар батлуулахаар Хорооны 01 тоот тогтоол гаргасан. Хорооны гишүүдээс гаргасан “3 төслийн форматыг нэг ижил болгох, Монгол-Англи нэр томъёоны тайлбар болон хамрах хүрээнд НББОУСХ-оос гаргасан СТОУС-ыг мөрдөнө гэж нэмэх, фермерийн гэсэн тодотголыг нэмэх, стандартын нэршилийг нэгдмэл болгох” гэсэн саналын дагуу холбогдох өөрчлөлт, засварыг оруулж, хорооны гишүүдэд 2016.12.13-ны өдөр хүргүүлэн, дахин санал авсан. “Барилгын гэрээний орлого ба зардлын нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ыг Сангийн сайдын 2016.12.16-ны 410 тоот тушаалаар баталсан.
		17.1.4.эдийн засгийн салбарын хэмжээнд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, заавар, аргачлал, маягыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, мөрдүүлэх;	Сангийн сайдын 2017 оны 192 дугаар тушаалаар "Аж ахуй нэгж, байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авах, хянах, нэгтгэл хийх, мэдээллийг ашиглах журам"-ыг шинэчлэн баталсан.
		22.2.Нягтлан бодох бүртгэлийн улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар олгоно.	Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 134 тоот тогтоолоор Улсын ерөнхий байцаагчийн эрхийг Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга байхаар баталсан.
		22.5.Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч нь шийтгэврийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд шийтгэврийн хуудасны загварыг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн 260 дугаар тушаалаар шийтгэвэрийн хэвлэмэл хуудас баталсан. Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлсний дараагаар энэ маягт шинэчлэн батлагдана.
3	<b>АУДИТЫН ТУХАЙ</b> /Шинэчилсэн найруулга/ 2015.06.19	18.1.3.аудитын хуулийн этгээдэд хийх чанарын хяналтын журмыг батлах;	Аудитын үйл ажиллагаа эрхэлж буй аудитын байгууллагуудад хуулийн шаардлага хангаж байгаа эзэх талаар хяналт, шалгалт хийх удирдамжыг боловсруулан Сангийн сайдын 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 181-р тушаалаар баталсан.

**Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас нийт 3 хуулийн 6 хэсэг, заалтыг хяналтаас хасах санал ирүүлсэн байна.**

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД БҮРЭН  
ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**  
/2017 оны эхний хагас жилийн байдлаар/

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	<p align="center"><b>Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай</b> 2016.11.17 №69</p>	<p>4/ 2. 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар баталгаажсан 10.8 их наяд төгрөгийн өглөгийг бууруулах;</p>	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, ТӨҮГ-уудад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2016-12-06-ны өдрийн 1/744, 1/745 дугаар албан бичгээр "Албан даалгавар" хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Уг албан даалгаварт алдагдал, өр төлбөр, авлагыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин бүрийг хангахад чиглэсэн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, түүний хэрэгжилт, үр дүнг info@pcsp.gov.mn цахим хаягаар ТӨБЗГ-т сар тутамд мэдээлж байх, хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр дүнг ТУЗ, удирдлагын үүрэг, хариуцлагатай холбон дүгнэх талаар тусгасан.</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгжүүд 2016 оны жилийн эцсийн байдлаар нийт өглөг 9,500,162.8 сая төгрөг болж, 2015 оны жилийн эцсийн дүнгээс 11.8 хувиар буюу 1,269,291.6 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн 2016 оны өр төлбөрийн дүнд Монгол улсын Хөгжлийн банк, Төрийн банкны өр төлбөрийн нийт дүн 5,808,695.0 сая төгрөг орсон бөгөөд энэ нь нийт өр төлбөрийн 61,1 хувь болж байна. Үүнд дээрх банкны эх үүсвэрийг бүрдүүлэхэд үүссэн өр, үнэт цаас, бондын өр зэрэг багтсан байна. Тухайлбал, Хөгжлийн банкны өр төлбөрт Самуурай бондын өр, бусад эх үүсвэрээс авсан өр төлбөр багтсан байна. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэлийн техник технологио шинэчлэх чиглэлээр 1,447,417.1 сая төгрөгийн урт хугацаатай зээлийг авсан дүнтэй байна.</p>
2	<p align="center"><b>Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай</b> 2015.12.03 №108</p>	<p>1.1/Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлж хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтаас хасагдсан, хавсралтад заасан төсөл, арга хэмжээнээс нэг маягийн зураг төслөөр барьж болох, 320 хүртэлх суудалтай сургууль, цэцэрлэг, дотуур байрын барилгыг 2016 оны 1 дүгээр улиралд багтаан концессоор хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төсөвт тусган ажиллах;</p>	<p>Улсын Их Хурлын 2015 оны 108 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын ЗГ-аас 2016 оны 2 дугаар сарын 01-ны өдрийн 73 дугаар тогтоолыг гаргаж Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийн концессын жагсаалтын жагсаалт"-ын 7 дахь хэсэгт 4613-4635 дугаар бүхий төсөл, арга хэмжээг нэмсэн. 2016.02.01-ний өдрийн 73 дугаар тогтоолыг батлагдсан холбогдуулан Хөрөнгө оруулалтын газраас 2016 оны 3 дугаар сарын 8-ны өдөр 4613-4635 дугаар бүхий төсөл, арга хэмжээний уралдаант шалгаруулалтыг 2 сарын хугацаанд зарлаж, 2016 оны 5 дугаар сарын 08-ны өдөр нээлтийг хийсэн бөгөөд Хөрөнгө оруулалтын газар хэлэлцээрийн үр дүнд гэрээний нөхцлийг хамгийн сайн харилцан тохирсон нэг оролцогчтой гэрээ байгуулах дүгнэлт гарган 2016 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулан 2016 оны 308 дугаар "Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай" тогтоолыг батлуулсан болно. УИХ-ын 2015 оны 108 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 2 дугаар сарын 01-ны өдрийн 73 дугаар тогтоолыг гаргаж Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлаж, "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-ын 7 дахь хэсэгт 4613-4635 дугаар бүхий төсөл арга хэмжээг нэмсэн.</p>



	<p>1.3/ эрүүл мэнд, боловсрол, цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас бусад салбарын бүх шатны төрийн байгууллагын ажил үүргийг оновчтой хуваарилах, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, төрийн үйлчилгээний зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, үүнтэй холбогдуулан ажлын цагийг уян хатан тогтоож үр дүнг цагаар тооцох, сул орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх зэргээр бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх замаар цалингийн зардлын 10 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний урсгал зардлын хэмнэлт бий болгох;</p>	<p><b>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам</b>  2017 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар тус яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Санхүүгийн хэлтэст 1, Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтэст 2, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт 1 нийт 4 сул орон тоонд томилгоо хийгдээгүйтэй холбогдуулан 4,138,967 сая төгрөгийн хэмнэлт гарсан байна.</p>
	<p>1.4/ төсвийн зардлыг бүх шатанд хэмнэж, бууруулахтай холбогдуулан 2016 оны төсвийн жилд өр авлага үүсгэхгүй байх, төсвийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зорилгоор батлагдсан урсгал зардлыг төсвийн ангилал хооронд хуульд зааснаар зохицуулалт хийж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт зөвшөөрөх;</p>	<p><b>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар</b>  Төсвийн шууд захирагчийн Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулах Үр дүнгийн гэрээнд байгууллагын төсвийг үр ашигтай, хэмнэлттэйгээр зарцуулж, өр, авлага үүсгэхгүй байх талаар тусгайлан заалт тусган ажиллаж байна. 2016 оны жилийн эцсийн тайлан балансаар өглөг, авлагагүй тайлагнасан.</p>
	<p>1.5/ нийслэл болон орон нутагт төрийн албан хаагчдын тоо, төрийн байгууллагуудын конторын барилга нэмэгдсэнээс урсгал зардал өсч байгаад дүгнэлт хийж, төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагуудын байршлыг оновчтой тогтоох, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, орон тоо болон конторын барилгын тоог бууруулж, байр ашиглалтын зардлыг хэмнэх;</p>	<p><b>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар</b>  Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ буюу байр ашиглалтын зардалд 61,9 сая төгрөгийн төсөв батлагдсан. 2016 оны 10 сарын 01-ний өдрийн №25/04 гэрээгээр Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаатай 61,9 сая төгрөгийн гэрээ байгуулж, 61,9 сая төгрөгийн зарцуулалт гарсан.</p>
	<p>1.8 /"Нэг эмнэлэг-хоёр жигүүр" концессын төслийн хэрэгжилтийн талаар Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцүүлэх;</p>	<p>"Нэг эмнэлэг-хоёр жигүүр" концессын төслийн хэрэгжилтийн талаар танилцуулга, "Төслийн хэрэгжилтийг хангах тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамдаас санал авч 2016.06.07-нд 1а/2440 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэгдэн дэмжигдэж, 2016.06.13-ны өдрийн Засгийн газрын "Төслийн хэрэгжилтийг хангах тухай" 323 дугаар тогтоол батлагдсан.</p>



3	<p><b>Нийслэл хотын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай</b> 2015.06.19 №64</p>	<p>1.1.Нийслэл хотод тогтмол явагддаг олон улсын чанартай үзэсгэлэнг зохион байгуулах болон хотын дэд бүтцийг сайжруулах асуудалд зарцуулах хөрөнгийг нийслэл хотын албан татварын орлогоор бүрдүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлж байх журам тогтоож, түүнийг холбогдох хууль тогтоомжид тусган мөрдөж ажиллах.</p>	<p>Нийслэл хотын албан татварын тухай хуулийг 2015 оны 6 дугаар сард УИХ-аар хэлэлцэн баталсантай холбогдуулан хуулийн хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлын хүрээнд нийслэл хотын албан татвар ноогдох бараа борлуулж, үйлчилгээ үзүүлж буй иргэн хуулийн этгээдийн үзлэг тооллого, бүртгэлжүүлэх ажлыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулж, албан татвар суутгагчийг татварын баазад бүртгэж авсан. Мөн Нийслэл хотын албан татварын тухай хууль баталсантай холбогдуулан хуулийн хэрэгжүүлэх аргачлал, хувь хэмжээг тогтоох төсөл, албан татвар суутгагчийг бүртгэх, бүртгэлээс хасах журмын төслийг боловсруулан Татварын ерөнхий газрын даргын тушаалаар болон Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. 2015.10.01-нээс хойш Нийслэлийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласнаар нийслэлийн төсөвт нийт 5893.6 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.</p>
4	<p><b>Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай</b> 2015.02.17 №36</p>	<p>1.10/цахилгаан эрчим хүч, ган, нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэж, экспортлох асуудлаар нэгдсэн бодлого боловсруулж 2015 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд танилцуулах;</p> <p>1.11/энэ тогтоолын 1 дэх заалтын 10 дахь дэд заалтад заасан нэгдсэн бодлогын агуулгад нийцсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах.</p>	<p>Цахилгаан эрчим хүч экспортлох асуудлаар нэгдсэн бодлого боловсруулж эрчим хүчний салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж чадахуйц суурь баримт бичиг болох “Эрчим хүчний салбарын хөгжлийн шинэчилсэн ерөнхий төлөвлөгөө” болон “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого”-д тус тус тусгаж өгсөн. Ган, нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэж экспортлох асуудлыг УУХҮЯ хариуцан хэрэгжүүлж байна.</p> <p>Дээрх заалтад заасан нэгдсэн бодлогын агуулгад нийцсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Эрчим хүчний яам, БНХАУ-ын Цахилгаан дамжуулах сүлжээ компани хооронд “Шивээ-Овоогийн цогцолбор төсөл”-ийн ТЭЗҮ хийж гүйцэтгэх гэрээг 2015.11.10-ны өдөр байгуулсан. Төслийн ТЭЗҮ-ийн судалгааны явцад хөрс хуулалтын коэффициент өндөр гарч эдийн засгийн үр ашиг муутай гарсан учир анх төлөвлөгдсөн 660 МВт-ын 14 ширхэг блокийн 9240 МВт-ын хүчин чадалтай станцыг 660 МВт-ын 8 ширхэг блоктой 5280 МВт болгож багасгахаар төлөвлөж төслийн хүчин чадалд өөрчлөлт орсон. Энэ тухай Монгол Улсын Их Хурлын даргын 2016.10.13-18-ны өдрүүдэд Хятад улсад хийсэн айлчлалын үеэр Эрчим хүчний сайдад Стейт Грийд корпорациас танилцуулсан. 2016.10.26-ны өдөр ЗГ-ын 422-р тогтоолын дагуу стратегийн ач холбогдол бүхий Шивээ-Овоогийн нүүрсний ордыг түшиглэн эрчим хүчний цогцолбор төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий төслийн нэгжийг “Эрчим хүчний яам” болон “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дэргэд байгуулсан. Төслийн нэгж нь сэргээгдэх эрчим хүч, дулааны цахилгаан станц, цахилгаан дамжуулах шугам, усан хангамж, нүүрсний уурхайн ТЭЗҮ боловсруулах ажилд дэмжлэг үзүүлэх, төслийн хэрэгжилтийг хангах зорилготой. Эрчим хүчний экспортын Шивээ-Энержи цогцолбор төслийн зорилго нь Монгол Улсад том хэмжээний дулааны цахилгаан станц барьж, үйлдвэрлэсэн эрчим хүчийг дотооддоо нийлүүлэхээс гадна БНХАУ руу цахилгаан дамжуулах шугамаар экспортлох юм. Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын “Экспорт-Импорт” банк хооронд 2015.11.10-ны өдөр байгуулсан нэг тэрбум ам.долларын зээлийн Ерөнхий хэлэлцээрийн хүрээнд “УБ-Мандалговь чиглэлийн 270 км цахилгаан дамжуулах агаарын шугам /ЦДАШ/, дэд станц барих” төсөл хэрэгжихээр болсон. “УБ-Мандалговь ЦДАШ, дэд станц барих” ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын “ТВЕА” групп ажиллахаар тендэрт шалгарсан. Шугамын шав тавих ёслолын ажиллагааг 2017.06.21-ний өдөр зохион байгуулсан.</p>
<p><b>Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас нийт 4 тогтоолын 9 заалтыг хяналтаас хасах санал ирүүлсэн байна.</b></p>			

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ БҮРЭН ХЭРЭГЖСЭН,  
ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**  
/2017 оны эхний хагас жилийн байдлаар/

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	<b>Засгийн газарт чиглэл өгөх тухай</b> /НБСШУБХ – ТБХ/ 2016.03.26 №09/03	1. Тусгай хэрэгцээт боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн харьяаллыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харьяанд шилжүүлэх	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль батлагдсантай холбогдуулан дагаж Бага, дунд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлд тусгай сургууль нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд байхтай холбогдох заалт нэмж орсон. Хуулийн заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран ажиллаж байна.
2	<b>Сургалтын төрийн сангийн зээлийн ашиглалт, төлөлт, төсвийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай</b> /НБСШУБХ-ТБХ/ 2013-04-16 04/04	1.9/ олон улсын нэр хүндтэй сургуулиудад Засгийн газраас тодорхойлсон эрэлттэй мэргэжил болон хөдөлмөрийн зах зээлд чухал шаардлагатай байгаа өндөр технологийн болон инженер, нийгмийн чиглэлийн мэргэжлээр суралцах оюутны тоог нэмэгдүүлэх,	1. Буцалтгүй тусламж. Сургалтын төлбөрийн хэмжээ, буцалтгүй тусламжид хамрагдах хүсэлтэй хүүхдийн тоо өссөнтэй холбоотойгоор буцалтгүй тусламжийн санхүүжилтийн хэмжээнд дээд жишиг тогтоон, төсөвт хүндрэлгүй, тэгш хүртээмжтэйгээр санхүүжилтийг зохион байгуулж байна. 2. Хөнгөлөттэй зээлээр суралцаж буй нийт 1830 суралцагчийн 568 сая төгрөгний сургалтын төлбөрийн тооцоо хийсэн ба дипломын эргэн төлөлт дээр онцгой анхаарч сурталчилгааны материал хэвлэн тарааж, онлайн сурталчилгаа тогтмол хийснээр нийт 411 суралцагч 273,3 сая төгрөгийн буцаан төлөлт хийж дипломоо гардан авсан. 2016-2017 онд дэлхийн шилдэг их дээд сургуульд бакалаврын боловсрол эзэмшихээр нийт 108, магистр, докторын боловсрол эзэмшихээр 44 оюутан элсэн суралцаж байна.
<b>Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас нийт 2 тогтоолын 2 заалтыг хяналтаас хасах санал ирүүлсэн байна.</b>			